

## ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2022 оны 02 дугаар сарын 07-ны өдөр

Орхон аймаг

Нэг талаас Эрүүл мэндийн газрын дарга Давааням овогтой Сүхээ /цаашид “А” тал/ нөгөө талаас ЭМГ-ын дэргэдэх Эцэг эхийн зөвлөлийн дарга Сэр-Од овогтой Мөнхзул /цаашид Б” тал / бид дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### 1. Нийтлэг үндэслэл

1.1. Гэрээний талууд нь “Хөдөлмөрийн тухай хууль”, “Хүүхдийн эрхийн конвенц”, “Гэр бүлийн тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Хүүхдийн эрхийн тухай хууль” болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид үндэслэн хамтран ажиллана.

1.2. Гэрээний “Б” тал нь байгууллагын албан хаагчдын хүүхдийн сурч боловсрох, эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх, соён гэгээрүүлэх, хүүхдэд ээлтэй байгууллага хамт олныг бий болгоход санаачлага гаргах, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, байгууллагын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх үүднээс Эрүүл мэндийн газраас үүрэг хүлээж хамтран ажиллана.

1.3. Гэрээний хугацаа 2022 оны 01 сарын 25-аас 2023 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал байна. Гэрээний хугацааг талууд тохиролцон сунгаж болно.

### 2. “А” талын хүлээх үүрэг

2.1. Хөдөлмөрийн тухай хууль “Хүүхдийн эрхийн конвенц”, “Гэр бүлийн тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Хүүхдийн эрхийн тухай хууль” түүнтэй холбогдсон, хууль тогтоомж болон гэрээгээр хүлээх үүргээ биелүүлнэ.

2.2. Зөвлөлийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан ажлын байр, тоног төхөөхөмж, багаж хэрэгсэлээр хангах.

2.3. Гэрээний зорилгод нийцсэн аливаа үйл ажиллагаанд “Б” талаас гаргасан саналыг судлан дэмжих.

2.4. Байгууллагын ажилтны тоо, цар хүрээ, боломжид тулгуурлан байгууллагын дэргэд хүүхдийн өдөр өнжүүлэх, албан хаагчдын амралтын өрөөг тохижуулах талаар дэмжлэг үзүүлэх.

2.5. Байгууллагын албан хаагчдын хүүхдийн төрсөн өдөр нь тохиож буй тухайн өдөр ажлын холбогдолтой сургалт, хурал гэх мэт цаг үеийн хойшлуулашгүй ажлаас бусад тохиолдолд ажлын хагас өдрийн цалинтай чөлөөг байгууллагын дарга тухайн ажилтантай зөвшилцсөнөөр олгож болно.

- 2.6. Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулагдах санхүүжилтэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх.
- 2.7. Сургуулийн бага ангийн болон цэцэрлэгийн насны хүүхэдтэй албан хаагчдад эцэг эхийн хуралд оролцох, эцэг эхийн эргүүл хийх боломжоор хангах
- 2.8. Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ажилтныг богиносгосон цагаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх
- 2.9. Олон улс, тив дэлхийн, улсын чанартай уралдаан тэмцээнд оролцож амжилт гаргасан хүүхдэд байгууллагын нэрэмжит дэмжлэг үзүүлэх, урамшуулах

### **3.“Б” талын хүлээх үүрэг**

- 3.1. Төлөвлөгөөний дагуу ажил үүргийг чанартай гүйцэтгэнэ.
- 3.2. Зохион байгуулсан үйл ажиллагааны талаар ажлын биелэлт, үр дүнг тайлагнана.
- 3.3. Зөвлөлийн үйл ажиллагаанд идэвхи санаачлага гарган ажилласан албан хаагчдыг байгууллагын зүгээс урамшуулан дэмжих, холбогдох байгууллагуудад шагналд тодорхойлно.
- 3.4. Сайн дурын байгууллага болон тухайн байгууллага ажилтан, албан хаагчынхаа хүүхдүүдэд хандив тусламж өгөх, нийгмийн хариуцлагын хүрээнд сайн дурын ажил зохион байгуулсан тохиолдолд хүүхдийн олон нийтийн өмнө онцгойлон нэрлэхээс татгалзах /амьдралын тувшин, бие, сэтгэхүйн өөрчлөлт зэргийг туслайлан онцлох/-оос татгалзах Хүүхдийн тухай мэдээллийг мэдээллийн хэрэгсэл, нийгмийн /Facebook, Instagram, Youtube гэх мэт/ цахим сүлжээнд ил тод зарлахгүй байна.
- 3.5. Байгууллагын нэр хүндтэй үлгэр дуурайлал болсон гэр бүлийг сурталчилах, урамшуулах
- 3.7. Цагдаагийн газар, ГБХЗХГ-тай хамтран ажиллана.
- 3.8. Шаардлагатай тохиолдолд хурал, зөвлөгөөнд оролцоно.

### **4.Хамтын ажиллагааны удирдлага, хяналт**

- 4.1. Гэрээний аль ч тал гэрээний хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй.
- 4.2. Гэрээний аль нэг тал нь нөгөө талын шаардсан үед хамтын ажиллагаатай холбоотой өөрийн хийсэн ажлын талаар тайлагнах үүрэгтэй.
- 4.3. Хамтын үйл ажиллагааны тайланг талууд явцын тухай шаардлагатай тохиолдолд хэлэлцэж байна.

### **5.Хариуцлага**

- 5.1. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй үед холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

### **6.Гэрээ хүчин төгөлдөр байх**

- 6.1. Талууд гэрээнд гарын үсэг зурсан үеэс гэрээ хүчин төгөлдөр болно.

6.2. Гэрээг хуульд зааснаас бусад тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгож болно.

6.3. Талууд тохиролцвол гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

<b>ЭМГ-ЫГ ТӨЛӨӨЛЖ:</b>  ЭМГ-ЫН ДАРГА  /Д.СҮХЭЭ /  2022 оны 01 сарын 07 өдөр	<b>ЗӨВЛӨЛИЙГ ТӨЛӨӨЛЖ:</b>  /С.МОНХЗУЛ /  2022 оны 01 сарын 07 өдөр
---	--

## ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ

1.3 заалтын дагуу гэрээний хугацааг талууд тохиролцон сунгаж байна

2022 оны ....сарын ....-ны өдрөөс 2022 оны .... сарын ...-ны өдөр хүртэл сунгав.

**ЭМГ-ЫГ ТӨЛӨӨЛЖ:**

ЭМГ-ЫН ДАРГА

**ЗӨВЛӨЛИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

/С.МӨНХЗУЛ /

2022 оны .... сарын .... өдөр

2022 оны .... сарын .... өдөр